

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРБТОРИ 23 ДУГААР СУРГУУЛИЙН ГЕРМАН ХЭЛНИЙ БАГШ Д.ЭНХТУЯАГИЙН ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

I. ТӨЛӨВШИЛ:

1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал
 - “Цэнэглэх цаг” бүрийг алгасалгүй сууж оюунаа хөгжүүлдэг
 - Бусад хичээлийн мэдлэг чадварын сорилуудын шалгалтыг ангиудаас авч протокол хөтөлсөн
 - БМДИ-ийн болон сургуулиас зохион байгуулсан сургалт семинарт сууж мэргэжлээ дээшлүүлдэг
 - Багш нарын хурал
 - Мэргэжил дээшлүүлэх сургалт
 - ИХ ЗАСАГ их сургуулийн төгсөгчдийн Илтгэх урлаг мэтгэлцээний тэмцээнүүдэд оролцож туршлага судалж байна.
 - Moodle шалгалтын системд суралцаж 3-р ангийн 3-р улирал, 4-р ангийн 3-р улирлын нэгж хөтөлбөрийг 4 ур чадварын даалгавар сорилтой нь байршуулж хийсэн.
 - 1,2,3,4-р улирлын цахим хичээлүүдийг боловсруулж бэлтгэсэн.
 - Гёте институтын сургалт, сургууль хоорондын туршлага судлах семинарт цаг тухайд нь хамрагдсан.
 - Хэлний наадамд герман хэлний 3,4 ангийн сурагчдыг нийтээр нь хамруулан оролцуулж урлагийн тоглолт хийсэн.
 - Их цэвэрлэгээнд идэвхтэй оролцсон.
 - Багш нарын шинэ жилийн үйл ажиллагаанд оролцсон.
 - Герман хэлний үсэглэлийн баяр, хэлний өдөрлөгүүдэд амжилттай оролцов.
 - Герман хэлний өдөрлөгийг зохион байгуулсан.
2. Дэгийн хэрэгжилт, дадал хэвшил суусан байдал
 - Хичээлийн 40 минутыг үр дүнтэй өнгөрүүлэх, хичээлийн минутыг өөрөө өөртөө зориулж мэдлэг олж авахын төлөө сурахыг зорилго болгон хичээлийн эхний 5 минутанд сурагчид бие биенийхээ шинэ үгийг шалгаж хэвшсэн.
 - Хичээл дээр бие биенээ элдвээр хэлэхгүй, хүндэтгэн харьцахыг тухайн 40 минутыг зорилт болгон хичээлээ явуулдаг
 - Жижүүр багшийн үүрэгт ажлыг сар бүр хийж дүгнүүлдэг.
 - 4-р цагийн завсарлагаанаар дасгалаа хийж хэвшлээ.
 - 7 хоногийн нэг өдрийг цээж бичгийн өдөр болгож хэвшлээ

3. Бусадтай харилцах зан чанар

- Германы мэдээллийн номын санд уншлагын үдэш зохион байгуулж, сурагчдын ном унших, бусадтай зөв боловсон харилцах, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлсэн.
- Сурагчид номын сангаар үйлчлүүлэх дадалд суралцаж байна.
- Багаар ажиллах арга барилд суралцаж байна.

4. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал хэвшил зан чанарын байдал

- Зан чанарын хувьд зөрчилтэй сурагчдыг эцэг эх, ангийн багштай нь ярилцан зан аашийг засах талаас нь ангийн үлгэр жишээч хүүхэдтэй суулган тэднээс суралцуулах дадалд хэвшүүлж байна.

5. Жижүүр багшийн үнэлгээ

- Жижүүр багшийн үүргийг сар бүр амжилттай сайн хийж бүгдэд нь 100%-н үнэлгээ авав. \3-4,4-1,5-27,6-3 \

6. Хэдэн судалгаа хийсэн, ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал

Хийсэн судалгаа	Ажилласан байдал	Үр дүн
Уншсан номын тэмдэглэл хөтөлдөг сурагчдын судалгаа	Сурагчдын уншсан номын утгыг хичээлийн сэдэвтэй уялдуулан зургаар зуруулж үзсэн	Сурагчдын уншсан номын утгыг хичээлийн сэдэвтэй уялдуулан зуруулж, утгыг яриулахад сурагчдын зурах болон өөрийгөө бусдад илэрхийлэх чадвар хөгжсөн.
Сурагчдын судалгаа	Сурагчид болон эцэг эхийн дэлгэрэнгүй судалгааг хийсэн.	Уг судалгааг хийснээр стандартын хоцрогдолтой сурагчдын эцэг эхтэй хамтарч ажиллан, хоцрогдлыг арилгасан. Германы мэдээллийн номын санд сурагчид герман хэл дээр ном, зурах бичиг уншихаас гадна өөрт тохирсон кино үзэх боломжтой болсон.
Авъяас чадварын судалгаа	Сурагчид хичээлээс гадуур ямар дугуйлан, секцэд хамрагддаг талаар судалгаа хийсэн.	Авъяас чадварын судалгаа хийснээр сурагчдын дуулах, бүжиглэх, жүжиглэх, шүлэг унших, зурах олон чадварыг цаашид хөгжүүлэх боломжууд гарч ирсэн. Тухайн хүүхдийг юунд авъяастайг мэдэж авсан. Ингэснээр

		сурагчийг тэр чиглэлээр нь хөгжүүлэх боломжтой болсон.
Ур чадварын судалгаа	Хэлний 4 чадвараар /унших, бичих, ярих, сонсох / судалгаа хийсэн.	Тухайн сурагчийн герман хэл сурах сонирхол нэмэгдэн, өөртөө итгэлтэй болж илүү сурах эрмэлзэлтэй болсон.
Дэвтрийн үйл ажиллагаа болон цүнхний эмх цэгцтэй байдлын судалгаа	Хүүхэд нэг бүрийн дэвтрийг шалгаж, цүнхэн дэх хичээлийн хэрэгслийн эмх цэгц хэр байгааг шалгасан.	Бүх сурагчид гэнэтийн шалгалтанд үргэлж бэлэн байж, цүнхэн дэх хичээлийн хэрэгсэл бусад эд зүйлсийг байнга эмх цэгцтэй авч явж хэвшсэн.

7. Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн

- АУБ нараар дамжуулан зарим хоцрогдсон сурагчдын эцэг эхэд мэдээлэл хүргүүлж давтлаганд хамруулав.
- Эцэг эхийн хурал Улирал бүр хийж багуудын ажил ярилцаж дүгнэв.
- Герман хэлний тэтгэлэгт хамрагдах талаар Гёте институтаас мэргэжилтэн урьж эцэг эхэд сургалт явуулав
- Хоцорсон сурагчдын хоцрогдол арилгах хувийн журнал нээж эцэг эхтэй хамтарч ажиллав
- Авьяаслаг -23 урлагийн наадамд сурагчдыг хөгжүүлэн хамтарч ажилласан.
- Герман хэлний үсэглэлийн баярын үйл ажиллагаанд орчин бүрдүүлэх , сурагчдын үзэсгэлэн гаргах үйлд хамтарч ажилласан.
- Хэлний өдөрлөгт хоолны соёлыг таниулах үйл ажилагаанд хамтарч ажилласан.
- Эцэг эхийн хуралд тогтмол сууж, эцэг эхэд герман хэл сурахад эцэг эхийн зүгээс юуг анхаарах, хүүхдэдээ хэл сурахад хэрхэн туслах талаар мэргэжлийн багшийн зүгээс тогтмол зөвлөгөө өгч хамтарч ажилласан.
- Германы мэдээллийн номын санд уншлагын үдшийг номын санч, Гёте институтын PASCH төслийн ажилтан Б.Бэрцэцэг нартай хамтарч зохион байгуулсан ба эцэг эхэд “ ном уншихад хүүхдүүддээ эцэг эхийн зүгээс хэрхэн дэмжлэг үзүүлэх вэ?” сэдвээр эцэг эхэд сургалт семинар явуулсан.

8. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн биелэлт

- Давтлага өгсөн өдөр эцэг эхэд сурагчдыг хүлээлгэн өгч байв.

- Сурагчдыг герман хэлний хичээл орох кабинетруу дагуулж явж, ангийн багшид буцааж хүлээлгэн өгч ажиллалаа.
- Тарахын өмнө шаардлагатай бол эцэг эхтэй нь сурагчдыг утсаар яриулсан.
- Халдварт өвчин гадуур их байгаатай холбогдуулан сурагчдад болон эцэг эхэд гадуур хүн ихтэй газар явахгүй байхыг санууллаа.
- Хичээл тармагц хүүхдүүдээ цагтаа авч байхыг анхаарууллаа.

9. Гранд дизайны зорилго зорилтын биелэлт

II. Мэдлэг чадвар ахиц, амжилт

1. Гарааны болон Оношлох үнэлгээ
2. Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /MOODLE/

Улирал бүрээр хичээлүүдийн хөтөлбөр, төлөвлөгөөг цаасаар гарган батлуулж, MOODLE сиситем–д байрлууллаа.

Улирал	Нэгж	Ээлжит	Даалгавар	Шалгалт
4	23	64	50	4

3. Стандарт хэрэгжилт

№	Судлагдхууны нэр	бүлэг	Нэгж хичээл		Ээлжит		Сайжруулсан хичээл
			боловсруулвал зохих	боловсруулж баталгаажуулсан	боловсруулвал зохих	Боловсруулж баталгаажуулсан	
1	3-Р АНГИ	ЗВ	12	12	40	40	12
2	4-Р АНГИ	4В	12	12	41	41	12
	НИЙТ		24	24	81	81	24

4-р анги

	дүгнэгдэх	дүгнэгдсэн	VIII	VII	VI	V	IV	III	II	I
III	61	61	20	22	8	11	0	0	0	0
IV	61	61	32	22	7	0	0	0	0	0

Дүгнэлт: 4-р ангийн сурагчдын хувьд хэлзүйн дүрэм, унших, ярих, болон сонсох даалгавруудыг тогтмол давтлагаар нийтэд нь өгч байсны үр дүнд даалгавруудын гүйцэтгэл жигд сайн дүгнэгдсэн, аливааг ойлгох хурд сайтай, идэвхитэй сурагчид олон ч, стандартын хоцрогдолтой сурагчид бас нэлээдгүй байлаа. Бичгийн болон унших суурь чадвар суугаагүй хэд хэдэн сурагчид байснаас багшийн зүгээс тогтмол давтлага өгч стандарт түвшинд хүргэсэн. Өгөгдсөн өгүүлбэрийг орчуулах, үйл үгийн хувирал зэрэг даалгаврыг зарим сурагчид дутуу хийсэн байсан. Цаашид хэлзүйн дүрэм, уншаад ойлгох зэрэг чадваруудыг анхаарах нь зүйтэй юм

3-р анги

	дүгнэгдэх	дүгнэгдсэн	VIII	VII	VI	V	IV	III	II	I
III	58	58	17	11	18	12	0	0	0	0
IV	58	58	30	20	4	4	0	0	0	0

Дүгнэлт: Зв ангийн сурагчдын хувьд үгийн сангийн дүрмийн мэдлэг сайн, унших чадвар сайн, ялгац гишүүн бичих чадвар сайн, герман үгнүүдийг монгол хэлрүү орчуулах чадвар сайн, байлаа. Харин сонсох, ярих чадварын хувьд цаашид улам хөгжүүлэх шаардлагатай

хэмээн үзэж илүү анхаарал хандуулан ажиллалаа. Мөн шинэ үгийн баялаг нэмэгдүүлэхэд анхаарч шинэ үгийн дэвтрийг тогтмол хөтлүүлэн ялгац гишүүнийг өнгө өнгийн тодруулагчаар будуулж хэвшүүлээ.

Дүгнэлт: Хэлзүйн дүрмийн даалгаврын гүйцэтгэл сайн үнэлэгдсэн бөгөөд зарим сурагчид эр,эм,эрс хүйсийн ялгац гишүүний ялгааг гаргаж чадаагүй, алдаа гаргасан байна. Баймж үйл үг болон бусад дүрмийн бус хувиргаатай үйл үгсийн хувирлыг хувирдаг бүтэц, асуулт, үгүйсгэлийг сайн ялган таниулж ажиллуулах шаардлагатай байна. Мөн бичгийн ажил нь өгөгдсөн төлөвлөлтийн дагуу богино өгүүлбэр болон үг бичих ажил дээр сурагчид дүрмийн болон агуулга найруулгын алдаанууд их гаргасан, мөн асуулт зохиохдоо асуух үг болон үгсийн дараалал алдагдсан зэрэг алдаа их байна. Дүрмийг хэрэглээ болгохын тулд өдөр бүр шинээр үзсэн үйл үг болон нэр үгийг , ашиглан өөр хоорондоо ярилцдаг ярианы цагийг хичээлийнхээ эхний 10 минутад гаргаж өглөө. Ингэснээр хүүхдийн ярих чадвар, үгийн баялаг, өөрийгөө илэрхийлж буй байдалд ахиц гарч буй нь ажиглагдлаа.

	ДҮГНЭГДЭХ	ДҮГНЭГДСЭН	VIII	VII	VI	V	IV	III	II	I
III улирал	119	119	28	33	32	26	0	0	0	0
IV улирал	119	119	62	42	11	4	0	0	0	0

4. Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт

- Гёте институтын сургалтуудад тогтмол сууж мэдлэгээ дээшлүүлж байна.
- Германы мэдээллийн номын санд амралтын өдрүүдээр сууж, бусад герман хэлний багш, хувь хүмүүсээс туршлага судалж, өөрийн мэдлэгээ нэмэгдүүлж байна.
- Moodle системийн сургалтанд тогтмол хамрагдаж 100% үнэлгээтэй сертификат авлаа.
- 3,4 ангийн бүх хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, нэгж ээлжитээ 4 улирлаар даалгавар тус бүрээр Moodle системд оруулсан.
- Багшийн мэдвэл зохих хуулийн ном, товхимол зэргийг байнга уншиж хуулийн мэдлэгээ нэмэгдүүлж байна.

5. Журнал бичилт

Журналыг өдөр бүр болон нэгж хичээл, улирлын дараа хөтөлж үр дүнг тооцон 5 дахь өдөр сургалтын албанд хураалгаж сургалтын менежерээс сайн хөтөлсөн үнэлгээг авч байсан.

6. Хичээлд ордог сурагчдын хүртээмж

3В ангийн 58 сурагчдад хичээл бүрээр хүүхдийн тоогоор тарааж өгөх материал, тестийг боловсруулж хэвлэн сургалтандаа ашигласны үр дүнд шалгалтыг амжилттай өглөө.

7. Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт

Багшийн хөгжлийн дэвтрийг өдөр бүр болон улирлын төгсгөлд нэгтгэж хөтлөн ажилдаа ашиглалаа. Энэхүү дэвтрийг хөтөлснөөр хийх ажлаа төлөвлөн тэмдэглэж түүнийхээ дагуу хийсэн ажлын үр дүнгээ тооцож, тайлан бичихэд дөхөм байсан.

8. Хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн бүтээлч ажил

- Гэрийн даалгаврыг тогтмол шалгаж, эцэг эхтэй хамтран ажилласан
- Нэгж хичээл бүрийн дараа үнэлгээг хийж үр дүнг эцэг эхэд танилцуулан анхаарах зүйл дээр хамтран ажилласан.
- Хичээнгүй бичиг бичих материалыг бичмэл хэлбэрээр сурагчдын эцэг эхэд хичээлийн эхэнд хувилж өгснөөр бичгийн хэлбэр сайжирсан .
- Хичээл ордог 4В,3В ангиудын сурагчдын түвшинд нь тохирсон үгтэй зурагт тоглоом тоглуулж, түүн дээр гарсан үгсийг цээжлүүлэх, богино хэмжээний үлгэр уншуулж, дүрийн тоглолт хийх зэргээр ярих, сурагчдыг багт хувааж харилцан яриулах, үзсэн хичээлийн сэдэвтэй холбоотой зураг зуруулж, яриулах, бүлэг сэдэв бүрийн дараа үзсэн үгсийг зурагт үзүүлэнгээр тоглох маягаар үг тус бүрээр үг бүтээлгэж тоглуулах зэргээр бичих чадварыг хөгжүүлдэг.
- Гёте институтаас зохион байгуулсан “Ах дүү гриммийн үлгэр”-ийг хэн сайн мэдэх вэ? зургийн уралдаанд нийт 30 сурагч зураг зурж оролцсоноос 1-р байрыг 4В ангийн Н. Мөнгөнболор, 2-р байрыг Г.Эгшиглэн нар тус тус авсан байна.
- Дэнлүүний баярыг угтаж дэнлүү яаж хийхийг сурагчдадаа зааж өгч, сурагчид өөрсдийн хийсэн дэнлүүгээр бүтээлийн үзэсгэлэн гаргасан.
- “Пушкин”-ы нэрэмжит шүлгийн тэмцээнд “өвөл” шүлгийг герман хэл дээр цээжлүүлэн уран уншуулж оролцуулсан.
- Хэлний наадамд бүх сурагчид идэвхтэй оролцож герман хэлээр сурсан мэдсэнээ тайлагнасан

- Уншлагын өдөр зохион байгуулахын тулд сурагчдаас уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх судалгаа авсан.
- Ангийн номын санг баяжуулж дүрмийн номнууд авсан.
- Кабинетдаа сурагчдын хичээл хийх идэвхийг нэмэгдүүлэхийн тулд хэрэгтэй зүйлээ авч ашиглаад буцаагаад хийдэг булан нээсэн.
- Сурагчдын хэлэхүйн авъяасыг хөгжүүлэхийн тулд хүүхэд тус бүрд түргэн хэллэгийг цээжлүүлсэн.
- Сурагчдын сонсгол, хэллэгийг сайжруулах үүднээс Гётөд хүүхдийн кинотой DVD,CD авах хүсэлт гаргасан. 6 хүүхдийн кинотой болж, сурагчид хичээл дээр кино үзэж сонсох чадвар нь сайжирч байгаа.
- Хичээлээс хоцорсон сурагчидтай хоцрогдол арилгах өдрүүд гаргаж сурагч бүртэй тулж ажилласан.
- MOODLE –ээс зураг, бичлэг харуулан хичээлээ заасан.

9. Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа байдал

- Анхаарах шаардлагатай сурагчдын эцэг эхтэй уулзаж асуудал бэрхшээлийг сонсож зөвлөгөө өгч ажилладаг. Гэрийн даалгаврыг хэрхэн хийлгүүлэх, тухайн сэдвийг хэрхэн давтуулах гэх мэт.
- Хичээлийн дараа авч үлдэх сурагчдаа урьдчилан эцэг эхэд нь хэлж сурагчдын ойлгохгүй байгаа зүйлийг зааж өгч дэмжлэг үзүүлсэн.

III. Авъяасыг нээн судлах

1. Сонирхлын судалгаа

- Дуулах , бүжиглэх, жүүиглэх, шүлэг унших,зурах , сонирхлын судалгаа авлаа. Дуулах сонирхолтой 34 сурагч, бүжиглэх сонирхолтой 22 сурагч байсан. Дуулах сонирхолтой сурагчдыг хэлний наадмын урд зогсоож дуулуулсан , 10 сурагчийг сонгон зургийн сургалтанд , 12 сурагчийг монгол бүжгийн сургалтанд хамрууллаа.

2. Дугуйлан секцэд хамрагдсан сурагчдын судалгаа /танхим ба танхимын бус/

№	Хамрагдсан дугуйлан секц	Төрөл	Хамрагдсан сурагчдын тоо
1	Шатар	Танхим бус	6
2	Зураг	Танхим бус	12
3	Таеквондо	Танхим бус	1
4	Гимнастик	Танхим бус	2
5	Балет	Танхим бус	1

3. Ангийн номын сангийн баяжилт

Сургуулийн номын сангийн баяжилтанд Гёте институтаас 22 ном өгсөн.

4-р ангийн бүх сурагчдыг 6 багт хуваан “Ах дүү Гриммийн Үлгэрүүд” номыг нийтээр нь уншуулан Гёте институтын 10 жилийн ойн баярт зориулан зохион байгуулсан зургийн тэмцээнд оролцуулсан.

4. Уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх

Германы мэдээллийн номын санд уншлагын үдэш зохион байгуулахын тулд сурагчдад “Антон гэж хэн бэ ?” гэсэн нэртэй хүүхдийн сургамжит номыг эхлээд сурагчдаар уншуулж, дараа нь утгыг тайлбарлан өгч дэвтэр дээр тэмдэглэл хөтлүүлсэн..

5. Бүтээлийн үзэсгэлэн гаргасан байдал

- Ах дүү Гриммийн үлгэрүүдийг хэн сайн зурах вэ” зургийн бүтээлийн үзэсгэлэнг ангийн хажуугийн самбар дээр, Герман хэлний үсэглэлийн баярын өдрөөр 2 давхрын самбар дээр цэвэр бичгийн үзэсгэлэн , урлаг заал, ханан дээгүүр сурагчдын өөрсдийн бүтээсэн бүтээлүүдийг тус тус гаргаж тавьсан.

6. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлсэн байдал /Улс нийслэл, дүүрэг, сургууль/

7. Олимпиад уралдаан тэмцээн

- Гёте институтаас зохион байгуулсан “Ах дүү Гриммийн үлгэр”-ийг хэн сайн мэдэх вэ? зургийн уралдаанд нийт 30 сурагч зураг зурж оролцсоноос 1-р байрыг 4В ангийн Н. Мөнгөнболор, 2-р байрыг Г.Эгшиглэн нар тус тус авсан байна.
- “Пушкин’-ы нэрэмжит шүлгийн тэмцээнд “өвөл” шүлгийг герман хэл дээр цээжлүүлэн уран уншуулж оролцуулсан.

8. Бүтээлч ажил
9. Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж анги нийтээрээ хөгжсөн байдал
 - Герман хэлний наадамд ангиараа 100% оролцсон..
 - 3-р ангийн бүх сурагчид нийт 8 дуу, 6 түргэн хэллэг, 4-р ангийн бүх сурагчид нийт 7 дуу 6 түргэн хэллэг, 2 шүлэг тус тус сурч мэдсэн байна.

10. Багш ажлын байран дээрээ хөгжсөн байдал

- -Мэргэжлийн ур чадвар, заах арга барилаа сайжруулахын тулд Дархан-уул аймгийн 19-р сургуулийн багш нарын хичээлд сууж тэмдэглэл хөтөлж, туршлага судаллаа.
- Баг хамт олонтой хамтран ажиллаж , сургууль хамт олны аливаа ажилд идэвхитэй оролцож байна
- Сурагчдад заах чадвараа дээшлүүлэхийн тулд интернет орчинд хичээл зааж буй багшийн цуврал хичээлүүдийг герман хэл дээр тогтмол үздэг.
- Moodle сиситемийн сургаланд тогтмол сууж байна.
- Цэнэглэх цагуудад тогтмол сууж өөрийгөө хөгжүүлж байна.

VI. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ

1. Цаг ашиглалт

- Хоцролт, таслалгүй цагийн алдагдал байхгүй ажилласан .
- Хичээл эхлэхээс 2 цагийн өмнө ирж тухайн өдрийн ээлжит хичээлийн ажлын хуудас, хэвлэх материалыг бэлддэг.
- Хичээл тарсны дараа маргааш орох ээлжит хичээлийн материалыг тогтмол бэлддэг.
- 7 хоног бүрийн багшийн цаг ашиглалтын төлөвлөгөөг тогтмол сургалтын албаар батлуулж ажиллалаа.

2. Сэтгэл ханамжын судалгааны үр дүн

- Герман хэлний хэлний гүнзгийрүүлсэн сургалттай, Алтанцэцэг багштай 4в ангиас зохион байгуулсан хуралд оролцож нийт 48 сурагчийн эцэг эхтэй уулзан сурагчдын явцын хичээлд оролцох байдал, төлөвшил хандлага, гэрийн даалгаварын биелэлт зэргийг хүүхэд тус бүрээр нь танилцуулан хамтарч ажиллах, хүүхдээ илүү сайн хайхрах тал дээр зөвлөгөө өгч ажиллалаа.
- Герман хэлний гүнзгийрүүлсэн сургалттай Анхбаяр багштай 3в ангийн эцэг эхийн хуралд оролцон хичээлд хүүхдүүд хэрхэн оролцдог, сурагчдын явц зэргийг эцэг эхчүүдэд танилцуулан анхаарах шаардлагатай сурагчдын эцэг эхтэй ганцаарчлан уулзаж зөвлөгөө өглөө.
- Ангийн сурагчидтай ажиллах групп нээж даалгавар тус бүрийг түүн дээр байршуулж эцэг эхийн хүүхэдтэйгээ ажиллах оролцоог нэмэгдүүллээ.

3. Хичээлийн цагийн хариуцлага-40 минут

- Хичээлийн 40 минутыг бэлтгэлийг сайн хийн цагийн алдагдалгүй зааж, ажлын хуудас болон тарааж өгөх нэмэлт материал, зураг , хичээлийн хэрэглэгдэхүүнийг хүүхдийн тоогоор , бэлтгэж хичээлийн хэрэглэгдэхүүнгүй сурагчийг зээлж авах булангаасаа байхгүй зүйлсийг нь өгөн, хичээлээ амжилттай явууллаа.

4. Багшийн ёс зүй, хууль эрх зүйн биелэлт

- Багшийн ёс зүйн дүрмийг баримтлан алдаа дутагдал гаргаагүй .

5. Багшийн хичээлийн бэлтгэл

- Хичээл бүрээр нэгж хичээл болгон дээр ээлжит хичээлийн хөтөлбөрийг бэлтгэн хэвлэж сургалтандаа ашигласан.

6. Хоцрогч таслагч сурагчидтай ажилласан байдал хүрсэн үр дүн

- Хоцорч тасалдаг сурагч байхгүй.

7. Багш сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлж байгаа байдал

- Багшийн журнал болон анги удирдагч багшийн журнал,багшийн хөгжлийн дэвтрийг цаг хугацаанд нь хөтөлж 5 дахь өдөр бүр сургалтын албанд хураалган шалгуулж өндөр үнэлгээ авч байсан.

8. Сургалтын техник хэрэгслийг ашигласан байдал

- Проектор болон дэлгэцийг сургалтын үйл ажиллагаанд тогтмол хэрэглэсэн. Цахим хичээл болон видео хичээлүүдийг сургалтандаа ашигласан.

9. Сурагчдын хөгжил төлөвшил эрсдэлийн судалгааны сан бүрдэлт

- Эрсдэлд өртөж болзошгүй сурагчдын судалгаа

№	Анги	Сурагчдын нэрс	Тайлбар
1	4в	Цэрэн-очир	Аав ээж нь авах боломжгүй өөрөө гэрлүүгээ ганцаараа явдаг, хичээлдээ ирдэг
2	4в	О.Мэндсайхан	Ээж нь жүжигчин кино зураг авалтанд хөдөөгүүр их явдаг аав нь ажил ихтэй өөрөө гэрлүүгээ ганцаараа явдаг, хичээлдээ ирдэг
3	4в	Т. Чингүүн	Аав нь томилолтоор хөдөө

			орон нутагт ажилладаг, ээж нь ажил ихтэй таксинд суулгаж өгдөг
4	4в	Б.Болорзаяа	Аав нь томиллолтоор хөдөө орон нутагт ажилладаг, ээж нялх хүүхэдтэй, аав ээж нь салсан

V. ЭРҮҮЛ МЭНД

1. Мэндлэх хүндлэх –Зөв боловсон харилцаа

- Ахмад хүн болон,багш нар тай тогмтол инээж боловсон харилцаж, судалж буй хэлээрээ зөв дуудлагатай мэндэлж хэвшлээ.

2. Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал

- Бие зассаны дараа гарын ариун цэвэр сахиж хэвшсэн.
- Үдийн цайны аяга таваг халбага сэрээг гэрт тогтмол угаалгаж сургасан.
- Ханиад хүрсэн тохиолдолд амны хаалтыг тогтмол хэрэглэж хэвшсэн.
- Анги танхимд агаар оруулах, цэвэрлэгээг хуваарийн дагуу тогтмол хийлгэж сургах талаар заавар өгсөн.
- Ангид жижиг чийгшүүлэгч авч, анги танхимын хуурай тоостой байдлыг багасагасан.
- Ангийн алчууруудыг өнгө өнгөөр төрөлжүүлж, алчуурын зөв хэрэглээг хэвшүүлсэн.
- Ангид цэцэг тарьж, тогтмол услахыг зааж сургасан.

3. Эрүүл мэндийн сургалт зохион байгуулж гарсан үр дүн

- Сургуулийн эмчийн халдварт өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Сургалтын үр дүнд халдварт өвчин гараагүй.

4. Анги танхимын цэвэр эмх цэгцтэй байдалд сургаж хэвшүүлсэн байдал

- Гадуур хувцасыг даавуун уутанд хийж өлгүүрт өлгүүлж сургасан.

Эрүүл орчинд байхын ач тусын талаар ойлголт өгч хэвшил болохуйц ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байдал

- Хувцсаа өлгүүрт өлгөж хэвшлээ..

- Их завсарлагаанаар ангид тогтмол агаар сэлгэж хэвшүүлээ.
 - Ангийн хуурайшилтыг багасгахын тулд агаар чийгшүүлэгч асааж чийгшилтийг хэмжээг нэмэгдүүлэв.
5. Жижүүр сурагчдын үйл ажиллагаа жигд ажиллагаатай эсэх
- Өдөр бүр 4 сурагч ангид цэвэрлэгээ хийж, цэцэг усан хогоо хаяж хэвшсэн.
6. Анги танхимын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар зөв ойлголт өгч, тэдгээртэй зөв харилцах дадал хэвшилд сургасан байдал
- Хогийн шүүр , хувин тосгуур зэргийн аюулгүй байдлыг хангаж тогтмол шкацанд хийлгаж хэвшүүлээ.205 тоот ангийн сандал ширээ ,эмх цэгц,ариун цэвэр,цэвэрлэгээ зэргийг өдөр бүр хариуцан цэвэрлэж ирлээ.
7. Эрүүл мэндийн үзлэг, сургалт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж хэрэгжүүлсэн байдал
8. Ангийн ариун цэвэр эрүүл мэндийн булангийн хэрэгжилт
- Смен ангийн сурагчид 7 хоногийн Бямба гаригт их цэвэрлэгээ хийж ширээ сандал, цонхны тавцан , шалыг угааж цэвэрлэдэг.
9. Эрүүл шүд-Эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн ажил
- Шүдний эмчийн үзлэгт хамруулж заавар зөвлөгөөг аван зуны амралтаар эрүүлжүүлэх даалгавар өглөө.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ


2018-2019 оны хичээлийн жилийн жилд нийт 119 сурагчид сургалтын үйл ажиллагааг төлөвлөн амжилттай зохион явуулж, сурагчдыг сургалтын явцад төлөвшүүлэх, зөв харилцаа тэр тусмаа бие биенээ хүндэтгэн сонсох харилцааны чадварт сургах, үнэлгээний өөрийн болон бусдыг шударгаар үнэлэх арга барилд сургах мөн сурагчид санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж, илтгэх чадвартай болгоход дэмжин ажилласан бөгөөд эдгээр чадварууд, арга барилыг тухай бүр ажиглан тэмдэглэх, хичээлийн хоцрогдолтой сурагчидтай тулж ажиллах, хүүхэдтэйгээ ажиллах эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхээр зорин ажиллаа. 3-р ангийн сурагчдын хувьд бичих, унших чадварыг түлхүү хөгжүүлэхийн тулд үсгэн хөзрийн тоглоом, зурагт үзүүлэн дээр ажиллуулах, сонсох чадварыг хөгжүүлэхийн тулд дуу шүлэг хэлэхүйн чадварыг хөгжүүлэхийн тулд түргэн хэллэг цээжлүүлээ. 4-р ангийн хувьд сонсголыг илүү түлхүү хөгжүүлэхийн тулд кино үзүүлэх, сурагчдын хувьд сонирхолтой тоглоомын аргуудыг хичээл заахдаа ашиглах үйл ажиллагааг явуулав. Цаашид төлөвлөсөн төлөвшил, хэлний 4 ур чадваруудыг хөгжүүлэх ажлаа нарийн тэмдэглэл хөтлөн сурагч бүрийн ахиц, амжилтыг тооцон ажиллах, хоцрогдолгүй сурагчтай

болохын тулд сайтар анхаарч ажиллах хэрэгтэй байна. Мөн 4-р ангийн сурагчдын хувьд гарааны дүнг дүгнэж үзэхэд сонсох болон уншиж ойлгох чадварыг түлхүү хөгжүүлэх шаардлагатай байсан. Хичээлийн явцад унших, бичих, сонсох, ярих 4 чадварыг хөгжүүлэх практик дасгал ажлуудыг түлхүү хийлгэснээр мэдлэг чадварын сорил шалгалт авахад эдгээр чадварууд гарааны дүнгийнхтэй харьцуулж үзвэл илүү сайжирсан нь харагдаж байна. 3-р ангийн хувьд гарааны дүнг авч үзвэл бичгийн чадвар дээр анхаарах шаардлагатай байсан. Үсгэн хэзрийн тоглоомын аргыг тогтмол хэрэглэснээр бичих чадвар сайжирч мэдлэг чадварын шалгалтанд нийт сурагчдын бичих чадварын дүн илүү сайжирсан байна.

Тайлан бичсэн:

Герман хэлний багш Д.Энхтуяа

МООДЛЕ СИСТЕМД НЭГЖ ХИЧЭЭЛИЙГ ЧАДВАРААР БАЙРЛУУЛСАН БАЙДАЛ



WEIHNACHTSLIED -TANNENBAUM

! Due 20 January 2019

i 0 of 62 Submitted

Шалгалт-III-I

1. Бичих-германы тэмдэглэлт баяруудыг зөв бичсэн бүлгийг сонгоно.
2. Бичих-зургийг үгтэй зөв холбох
3. Сонсох -Дэнлүү дууг сонсоод 5 нэр үгийг бичнэ
4. Уншиж ойлгох-Дэнлүү гэсэн дууны үгсийг уншаад тохирох цэгийн оронд нөхөж бичих
5. Уншиж бичих- Бэлдсэн теостнээс германы баяруудын тэмдэглэдэг өдрүүдийг сонгож дугуйлах

Шалгалт-III-I

i 0 of 62 Attempted



D.ENKHTUYA



0% Complete



Der unbestimmte Artikel



Der Zungenbrecher



der Zungenbrecher



0% Complete



Die Bezahlung



Die deutsche Feiertage



Die Feiertage



die Feiertage



ANNOUNCEMENTS

No news items to display

Recently accessed courses



Ueber Deutschland




THEATER



Die Feiertage




der Zungenbrecher



Course overview





4-Н УР ЧАДВАРААР ХҮҮХЭД ХӨГЖҮҮЛЭХ БУЛАН



ЗЭЭЛЖ АВАХ БУЛАН БАЙГУУЛАВ.



НЭГЖ ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН СЭДВЭЭР КАБИНЕТАА ТОХИЖУУЛАВ .



**ГЕРМАНЫ МЭДЭЭЛИЙН НОМЫН САНД УНШЛАГЫН ҮДЭШ ЗОХИОН БАЙГУУЛЖ,
СУРАГЧИДАЙ НОМЫН САНД УНШСАН НОМНЫХ НЬ ТАЛААР ЯРИЛЦАЖ БАЙГАА
НЬ**



ХҮҮХЭДДЭЭ НОМ УНШИХАД НЬ “ЭЦЭГ ЭХИЙН ЗҮГЭЭС ЯАЖ ТУСАЛЖ ДЭМЖИХ ВЭ
СЭДЭВТ “ СУРГАЛТ ЯВУУЛЖ БАЙГАА НЬ



“УНШЛАГЫН ҮДЭШ” ЗОХИОН БАЙГУУЛАХАД СУРАГЧДЫН УНШСАН НОМ



**“АХ ДҮҮ ГРИММИЙН ҮЛГЭРҮҮДИЙГ ХЭН САЙН СУРАХ ВЭ” СЭДЭВТ ЗУРГИЙН
УРАЛДААНД ОРОЛЦОЖ ШАГНАЛТ БАЙРАНД ОРСОН СУРАГЧИД**



ХЭЛНИЙ НААДАМ 2019.05.10



ГЕРМАН ХЭЛНИЙ ӨДӨРЛӨГИЙН ХООЛНЫ СОЁЛЫН ТАНИЛЦУУЛГА



СУРГУУЛЬ ТАНИЛЦУУЛАХ ЗУРАГ АВАЛТЫН ҮЕЭР



ХЭЛНИЙ ӨДӨРЛӨГИЙГ УГТСАН АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ :

**ГЁТЕ ИНСТИТУТЫН PASCH ТӨСЛИЙН АЖИЛТАН Б. БЭРЦЭЦЭГ ХБНГУ-ЫН
ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААР 3В,4В АНГИЙН ЭЦЭГ ЭХЭД СУРГАЛТ ЯВУУЛАВ**



4В СУРАГЧДЫН ХОЦРОГДОЛТОЙ СУРАГЧДЫН ДАВТЛАГА



3В АНГИЙН ХОЦРОГДОЛТОЙ СУРАГЧДЫН ДАВТЛАГА

